

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2024/163/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn Дорноговь аймаг Сайншанд сум 2024 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: domogovi@audit.gov.mn

2024 02 28 № 1-6/200

танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.УРАНБИЛЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын 3 ширхэг 19,000.0 мянган төгрөг бүхий захирлын А тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө,

012021041

мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн хуулийн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

И-баримт-ын системд 5 ширхэг 3,000.0 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасан заалтуудыг тус зөрчсөн байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний 7 үзүүлэлтэд арга хэмжээний хэрэгжилт 76.5 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 74.0 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,064,437.43	146,255,549.31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	17,286,586.99	86,951,671.98
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	17,286,586.99	86,951,671.98
31210	Төгрөг	17,286,586.99	86,951,671.98
31211	Төрийн сангийн харилцах	17,286,586.99	86,951,671.98
33	АВЛАГА	966.71	697,380.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	966.71	697,380.00
35	БАРАА МАТЕРИАЛ	60,776,883.73	58,606,497.33
35100	Түүхий эд материал	31,285,070.83	31,935,390.83
35110	Тусгай зориулалттай материал	30,252,240.83	30,928,140.83
35130	Эм боох материал	1,032,830.00	1,007,250.00
35400	Хангамжийн материал	29,491,812.90	26,671,106.50
35410	Бичиг хэргийн материал	1,468,860.00	1,344,800.00
35420	Аж ахуйн материал	3,173,050.00	2,989,850.00
35450	Барилгын засварын материал	44,110.00	44,110.00
35460	Хүнсний материал	7,424,312.60	4,930,866.20
35470	Бусад хангамжийн материал	17,381,480.30	17,361,480.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	366,515,705.84	383,729,304.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,515,705.84	383,729,304.62
39200	Биет хөрөнгө	361,900,372.40	379,201,971.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	318,305,740.00	318,305,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30,314,832.48	-37,893,540.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	500,000.00	500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-125,000.01	-291,666.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	53,018,935.46	48,772,595.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,500,495.28	-21,907,342.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,630,830.01	29,100,050.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,505,622.91	-12,483,091.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	51,324,578.00	71,224,578.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,417,733.15	-18,196,023.19
39217	Ном	1,983,972.76	2,070,672.76
39300	Биет бус хөрөнгө	4,615,333.44	4,527,333.48
39301	Програм хангамж	387,000.00	387,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-269,666.56	-357,666.52
39303	Бусад биет бус хөрөнгө	4,498,000.00	4,498,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	444,580,143.27	529,984,853.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	228,633.58
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	228,633.58
41300	Өглөг	0.00	228,633.58
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	228,633.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	444,580,143.27	529,756,220.35
51	Засгийн газрын хувь оролцоо	444,580,143.27	529,756,220.35
51100	Засгийн газрын оруулсан капитал	294,543,093.24	294,543,093.24
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	294,543,093.24	294,543,093.24
51200	Хуримтлагдсан үр дүн	150,037,050.03	235,213,127.11
51210	Өмнөх үеийн үр дүн	-335,812,914.74	150,037,050.03
51220	Тайлант үеийн үр дүн	485,849,964.77	85,176,077.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	444,580,143.27	529,984,853.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	735,889,089.23	397,578,442.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	449,246,695.74	37,461,325.00
120	Нийтлэг татварын бус орлого	449,246,695.74	37,461,325.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,921,500.00	17,180,925.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,818,000.00	17,180,925.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	384,025,578.11	19,931,700.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	59,299,617.63	348,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286,642,393.49	360,117,117.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	237,575,100.00	319,579,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	237,575,100.00	319,579,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,067,293.49	40,537,417.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,067,293.49	40,537,417.36
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	250,039,124.46	312,402,365.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,039,124.46	312,402,365.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,039,124.46	312,402,365.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,783,280.03	191,535,741.24
210101	Үндсэн цалин	136,718,090.03	155,356,063.63
210102	Нэмэгдэл	27,497,866.00	33,011,257.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	9,567,324.00	3,168,420.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,386,068.26	29,098,849.06
210201	Тэтгэврийн даатгал	14,573,031.79	18,727,849.06
210202	Тэтгэмжийн даатгал	1,779,029.92	2,592,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,382,784.07	2,074,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	339,060.63	518,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,312,161.85	5,185,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	40,256,917.36
210301	Гэрэл, цахилгаан	0.00	5,646,223.01
210302	Түлш, халаалт	0.00	30,009,000.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	4,601,694.35
2104	Хангамж, бараа материалын зардал	308,320.00	0.00
210401	Бичиг хэрэг	89,920.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	218,400.00	0.00
2105	Нормативт зардал	22,207,596.90	18,093,387.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	211,700.00	0.00
210502	Хоол, хүнс	21,995,896.90	18,093,387.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,000.00	525,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,000.00	525,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,143,859.27	32,892,470.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,617,525.00	11,278,444.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,198,462.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,327,872.27	21,614,026.02
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	485,849,964.77	85,176,077.28
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	485,849,964.77	85,176,077.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	286,745,893.49	360,117,117.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,500.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	103,500.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	103,500.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286,642,393.49	360,117,117.36
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	237,575,100.00	319,579,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	237,575,100.00	319,579,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,067,293.49	40,537,417.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,067,293.49	40,537,417.36
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	269,459,306.50	288,737,032.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,459,306.50	288,737,032.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,459,306.50	288,737,032.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,591,804.04	192,233,121.24
210101	Үндсэн цалин	133,152,311.04	154,658,683.63
210102	Нэмэгдэл	30,296,409.00	34,406,017.22
210104	Урамшуулал	13,143,084.00	3,168,420.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,840,157.97	28,869,248.77
210201	Тэтгэврийн даатгал	13,996,784.81	18,498,248.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,182,165.79	2,592,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,877,752.64	2,074,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,223.15	518,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,264,231.58	5,185,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,708,174.49	40,256,917.36
210301	Гэрэл, цахилгаан	3,064,940.49	5,646,223.01
210302	Түлш, халаалт	30,009,000.00	30,009,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,634,234.00	4,601,694.35
2105	Нормативт зардал	25,092,990.00	19,375,625.00
210502	Хоол, хүнс	25,092,990.00	19,375,625.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,100.00	280,500.00
210604	Урсгал засвар	445,100.00	280,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	210,000.00	528,080.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,000.00	528,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,571,080.00	7,193,540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,291,080.00	5,608,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,280,000.00	1,584,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	17,286,586.99	71,380,084.99
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,715,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,715,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,715,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1,715,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-1,715,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	17,286,586.99	69,665,084.99
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	17,286,586.99
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,286,586.99	86,951,671.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,543,093.24	-335,812,914.74	-41,269,821.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,543,093.24	-335,812,914.74	-41,269,821.50
9	Тайлант үеийн үр дүн	0.00	485,849,964.77	485,849,964.77
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,543,093.24	150,037,050.03	444,580,143.27
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	294,543,093.24	150,037,050.03	444,580,143.27
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,543,093.24	150,037,050.03	444,580,143.27
19	Тайлант үеийн үр дүн	0.00	85,176,077.08	85,176,077.08
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	294,543,093.24	235,213,127.11	529,756,220.35

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	336,866,200.00	249,914,615.01		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,866,200.00	249,914,615.01	86,951,584.99	74%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,866,200.00	249,914,615.01	86,951,584.99	74%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	262,812,400.00	192,233,121.24	70,579,278.76	73%
210101	Үндсэн цалин	174,324,000.00	154,658,683.63	19,665,316.37	89%
210102	Нэмэгдэл	78,455,700.00	34,406,017.22	44,049,682.78	44%
210104	Урамшуулал	10,032,700.00	3,168,420.39	6,864,279.61	32%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,851,100.00	28,869,248.77	3,981,851.23	88%
210201	Тэтгэврийн даатгал	22,338,800.00	18,498,248.77	3,840,551.23	83%
210202	Тэтгэмжийн даатгал	2,627,900.00	2,592,600.00	35,300.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,102,600.00	2,074,300.00	28,300.00	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	525,500.00	518,400.00	7,100.00	99%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,256,300.00	5,185,700.00	70,600.00	99%
2105	Нормативт зардал	31,048,800.00	19,375,625.00	11,673,175.00	62%
210502	Хоол, хүнс	31,048,800.00	19,375,625.00	11,673,175.00	62%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	528,200.00	528,080.00	120.00	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	528,200.00	528,080.00	120.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,625,700.00	8,908,540.00	717,160.00	93%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,041,000.00	7,323,840.00	717,160.00	91%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,584,700.00	1,584,700.00	0.00	100%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	336,866,200.00	319,579,700.00	17,286,500.00	95%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	319,579,700.00	319,579,700.00	0.00	100%
310001	Улсын төсвөөс санхүүжих	319,579,700.00	319,579,700.00	0.00	100%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,286,500.00	0.00	0	0%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	17,286,500.00	0.00	0	0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,814.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 25,814.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайлангуудын уялдаа холбоог шалгахад өмнөх оны үр дүнгээр 6,542.5 мянган төгрөгийн зөрүү илэрснийг
2. Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг бүртгэхдээ тохируулах бичилт буруу хийснээс Санхүүгийн үр дүнгийн тайлан 19,931.7 мянган төгрөгөөр буруу тайлагнагдсан байсныг
3. Үлдэх өртөг нь хасах -659.3 мянган төгрөгийн утгатай байсныг тус тус залруулав.

Аудитаар нийт 23,829.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 23,829.3 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар тогтоосон зөрчлийн 1829.3 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчилд хамаарч байгаа нь бидний тогтоосон материаллаг түшингээс байгаа байх тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд ажиллагчидтай холбогдсон 697.4 мянган төгрөгийн авлага хамгийн өндөр өсөлттэй байлаа.

Зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах

2. Илрүүлэлт:

Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтан М. Мөнхцэцэгтэй хуулийн хугацаанд ээлжийн амралтын тооцоо 903.3 мянган төгрөгийг хийж олгоогүйгээс нийгмийн даатгалын тайланд орхигдуулсан.

Зөвлөмж:

Ажилтантай хуулийн хугацаанд ээлжийн амралтын тооцоо хийж, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нь нийгмийн даатгалын тайланд тусгаж, нийгмийн даатгалын тухай хуулийг мөрдөж ажиллах

3. Илрүүлэлт:

Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд 228.6 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөрийг төлөөгүй байна.

Зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг мөрдөж ажиллах

4. Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын 3 ширхэг 19,000.0 мянган төгрөг бүхий захирлын А тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

Зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн хуулийн заалтуудыг тус тус мөрдөж ажиллах

5. Илрүүлэлт:

И-баримт-ын системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И-баримт-ын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 14 ширхэг 16.8 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтай нь шалгахад 5 ширхэг 3,000.0 мянган төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Зөвлөмж:

НББ-ийн тухай хуулийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасан заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй	
							Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангуудын уялдаа холбоог шалгахад өмнөх оны үр дүнгээр зөрүү илэрснийг залруулсан.	1	6,542.52			1	6,542.52	1	6,542.52		
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг бүртгэхдээ тохируулах бичилт буруу хийснээс Санхүүгийн үр дүнгийн тайлан буруу тайлагнагдсан байсныг залруулав.	1	19,931.70			1	19,931.70	1	19,931.70		
Үлдэх өртөг нь хасах утгатай үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоог дахин хийж үлдэх өртгийг залруулав.	1	-659.27			1	-659.27	1	-659.27		
ДҮН	3	25,814.96	0	-	3	25,814.96	3	25,814.96		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн						
Зөрчлийн товч утга														
Санхүүгийн байдлын тайланд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд ажиллагчидтай холбогдсон авлага хамгийн өндөр өсөлттэй байна.	1	697.38							1	697.38				

